



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2021.01.07 № 07/63
танай _____-ны № _____-т


“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН
ТАНАА

“Түр журам батлах тухай” Уул уурхай, хүнд
үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Зам,
тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2020 оны
А-337, А/630, А/238 дугаар тушаалын хуулбарыг
хавсралтаар хүргүүлж байна.

Хамтарсан тушаалын хэрэгжилтийг ханган
ажиллана уу.

Хавсралт: 7 хуудастай.

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА *Мунгал* ЁЖАРГАЛСАЙХАН



080055

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 12 сарын 30-ны

Дугаар А-329/1630-238


Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.1.14 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.21, 20.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 183 дугаар тогтоолын 9 дэх хэсэг, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 41 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ажилтнуудын ээлж солилцож, шилжилт хөдөлгөөн хийх үйл ажиллагаанд баримтлах түр журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, холбогдох байгууллагуудад мэдэгдэж, зохих арга хэмжээ авч, хяналт тавьж хамтран ажиллахыг Гамшгаас хамгаалах Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны Шуурхай штаб /Г.Нандинжаргал/, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай штаб /Я.Амаржаргал/, аймаг, нийслэлийн Онцгой комисст тус тус үүрэг болгосугай.



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Эрүүл мэндийн сайд, Зам, тээврийн
хөгжлийн сайдын 2020 оны 12 дугаар
сарын 30-ны өдрийн 73/460/... дугаар
хамтарсан тушаал, хавсралт

АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖ СОЛИЛЦОЖ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ТҮР ЖУРАМ

СБТ9513

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Коронавируст халдварын тархалттай холбоотой өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэргийн үед хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт компани болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, тээвэрлэгч, харуул хамгаалалтын аж ахуйн нэгж байгууллага (цаашид “аж ахуйн нэгж, байгууллага” гэх)-ууд нь ажилтнуудын ээлж солилцож, шилжилт хөдөлгөөн хийх үйл ажиллагаагаа зохион байгуулахдаа энэхүү түр журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.2. Түр журмаар зохицуулж буй үйл ажиллагаа нь Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын тогтоол, Улсын онцгой комиссын даргын тушаал, Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан тушаал, журам, заавар, зөвлөмжид тулгуурласан байна.

1.3. Энэхүү түр журам нь ээлжийн ажилтан ажиллаж байгаа газраасаа оршин суух нутаг дэвсгэр рүү зорчих, мөн оршин суух нутаг дэвсгэрээс ажлын талбар хүртэл зорчиход үйлчилнэ.

1.4. Энэхүү түр журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журмаар зохицуулна.

Хоёр. Төрийн захиргааны төв байгууллагуудын үүрэг

2.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аж ахуйн нэгж байгууллагууд, тэдгээрийн ажилчдын нэгдсэн тоо бүртгэл, тэдгээрийн ажиллах ээлжийн хуваарь, нэг ээлжинд ажиллах ажилтны тоо зэрэг мэдээллийг авч, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түр журмын 2.1-д заасан мэдээлэлд үндэслэн аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтнуудаас шинжилгээ авах цэгийн байршил, ажиллах хуваарийг гаргаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны шуурхай штабт хүргүүлнэ.

2.3. Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аж ахуйн нэгж байгууллагын ажилчдын нэгдсэн тоо бүртгэлийг ажилтны шинжилгээний хариутай тулгаж хот хоорондын зорчигч, тээвэрлэлтийг асуудлыг зохион байгуулна.

2.4. Халдвар хамгааллын дэглэм сахих, аюулгүй байдлыг хангах, шинжилгээ авах эмнэлгийн байгууллагын ажиллах боломж нөхцөлөөс хамаарч аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн ээлжийн хуваарьт заасан хугацаанд багтаан шинжилгээг авах боломжгүй бол зохицуулалт хийх талаарх мэдэгдлийг аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан хүргүүлнэ.

Гурав. Аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг

3.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь шилжилт хөдөлгөөн хийж байгаа ажилтнуудын оршин сууж байгаа хаягийн бүртгэл, ар гэрийн судалгааг бүрэн гаргаж, шаардлагатай үед холбоо барих бусад хүний утсыг тэмдэглэж, мэдээлэл харилцааны тасралтгүй үйл ажиллагааг бий болгоно.

3.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь түр журмын 2.1-д заасан мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон шаардлагатай бусад этгээдэд хүргүүлж, түр журмын 2.2-т заасан хуваарийн дагуу холбогдох ажилтнуудаа шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

3.3. Түр журмын 2.4-т заасан нөхцөл байдлаас хамаарч ажилчдын шинжилгээ өгөх хугацаанд өөрчлөлт гарах тохиолдолд ээлжийн хуваарьт шаардлагатай зохицуулалтыг хийж ажиллана.

3.4. Аж ахуйн нэгж, байгууллага шилжилт хөдөлгөөн хийх ажилтнуудынхаа холбогдох мэдээлэл /аймаг, нийслэлд зорчих шаардлага, иргэний бүртгэл, эрүүл мэндийн байдал болон тэдгээрийн ар гэрт нь ойрын болон дам хавьталд тусгаарлагдсан, КОВИД-19 халдвараар өвчилсөн хүн байгаа эсэх зэрэг болон бусад мэдээлэл/-ийг үнэн зөв гаргаж, хүсэлтээ Аймаг, Нийслэлийн Онцгой комисст цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.5. Аж ахуйн нэгж, байгууллага нь ажилчдын ээлж солилцох, шилжилт хөдөлгөөн хийх тохиолдолд ээлж солилцох хуваарь, хамрах хүний тоо зэрэг мэдээллээ аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт ээлж солихоос өмнө ажлын 2-3 хоногийн өмнө мэдэгдэх бөгөөд энэхүү мэдээлэл хийх албан тушаалтныг томилон нэр, холбоо барих утас, цахим хаяг зэргийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн байна. Мөн ээлжээс буух болон ээлжинд гарах хуваарь, ажилчдын тоог Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Шуурхай штабын мэдээллийн erdenetsetseg@mmhi.gov.mn, lkhamsuren.b@mmhi.gov.mn хаягаар мэдэгдэнэ.

3.6. Оршин суудаг нутаг дэвсгэрээс ажлын байр байрлах нутаг дэвсгэрлүү зорчих ажилтныг зорчих хугацаанаас өмнө 72 цагийн дотор КОВИД-19 вирусн PCR оношлуураар шинжилгээ өгүүлж, хариуг авсан байх ба уг ажлыг Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулна.

Асуумжийг бөглүүлж, асуумжийн хариунд судалгааг хийж, сэжигтэй болон голомтот газраас явах ажилтныг анхааралдаа авч, хяналтыг тавина.

3.7. Тухайн ээлжнээс бууж оршин суудаг нутаг дэвсгэр рүүгээ явах ажилтанд зорчих хугацаанаас өмнө 48 цагийн дотор КОВИД-19 вирусн түргэвчилсэн

оношлуураар шинжилгээ хийх ажлыг орон нутгийн Онцгой комисстой хамтран зохион байгуулсан байна.

3.8. Ажлын байр байрлах нутаг дэвсгэрээс гарах, буцаж орох ажилтнуудыг зорчихын өмнө эрүүл мэндийн байдалд тандалт хийж, халууныг хэмжин, тэмдэглэл хөтөлсөн байна.

3.9. Ажилтнуудад хамгаалах хэрэгсэл нэг удаагийн амны хаалтыг 2 цаг тутамд хэрэглэхээр, хаягдал цуглуулах гялгар уут, нойтон алчуур, гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай уусмал, нэг удаагийн бээлий, ариун цэврийн цаасыг зэрэг хамгаалах хэрэгслийг зорчих хугацаанаас нь хамааруулан хүрэлцээтэй байхаар бүрэн хангаж, хэрэглэх зааварчилгаа өгнө.

3.10. Шилжилт хөдөлгөөн хийж байгаа ажилтан тус бүрээр дамжин өнгөрөх, шилжин явах замын маршрутын судалгааг зайлшгүй үнэн зөв гаргасан байна.

3.11. Ажилтны тээврийн хэрэгсэлд суух суудлын тоог тогтоож, хүн хоорондын аюулгүй зайг баримталж, тээврийн хэрэгслийн дугаар болон суух зорчигчдын бүртгэл хөтөлсөн байна.

3.12. Зорчигч тээвэрлэлтийн бүх үе шатанд байнгын хяналт тавьж тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулахгүй байх арга хэмжээг авсан байна.

3.13. Зорчих чиглэл, маршрут, хөдлөх цагийн хуваарийг урьдчилан баталж, жолоочид заавар, чиглэл, шаардлагатай тохиолдолд холбоо барих хүн, мөн холбогдох аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын утасны дугаарыг бэлтгэж өгсөн байна.

3.14. Тээврийн хэрэгслийн бүрэн байдлыг шалган, хангуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулсан байх бөгөөд шаардлагатай бол (аяллын үргэлжлэх хугацаанаас хамааруулж) ээлжийн жолоочийг томилсон байна.

3.15. Ажилтнуудад коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуй, халдваргүйжүүлэлт, хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах талаар сургалт танилцуулга зохион байгуулсан байна.

3.16. Тээврийн хэрэгслийн кабинд Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг ил байршуулж, мэдээллээр тогтмол хангана.

3.17. Тээвэрлэлтийн явцад хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх арга хэмжээг авч, үүссэн ахуйн хог хаягдлыг зориулалтын уутанд хийлгэн, хогийн цэгт төвлөрүүлэн устгах арга хэмжээ авна.

3.18. Ажилтнууд хоорондын зайг баримталж, суудал алгасч суулгахаар зохицуулалт хийж, тэмдэг тэмдэглэгээг бүрэн хийсэн байна.

3.19. Ажилтнуудыг зөөвөрлөсөн тээврийн хэрэгслийн кабин болон гадаргууд хийх халдваргүйжүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/269 дүгээр тушаалын 8 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ.

3.20. Халдваргүйжүүлэлтийн бодис нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, хэрэглэх ашиглах заавар нь баталгаажсан, хэрэглэх хугацаа дуусаагүй, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй, тодорхой хаяг шошготой байна.

3.21. Зөвшөөрөгдсөн ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис /спиртэн суурьтай/-ыг ашиглуулж, халдваргүйжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

3.22. Халдваргүйжүүлэлт хийх ажилтныг хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн байна.

3.23. Халдварын сэжигтэй, магадлалтай болон батлагдсан тохиолдол илэрсэн үед голомтын эцсийн халдваргүйжүүлэлт, хог хаягдлын устгалыг нийслэлд Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймагт Зоонозын өвчин судлалын төв хариуцан хийнэ.

3.24. Энэ түр журмын 3.6, 3.7-д заасан шаардлага хангаагүй болон КОВИД-19 вирусын түргэвчилсэн оношлуураар шинжилгээний хариу сэжигтэй гарсан тохиолдолд нийслэл, аймаг, сум хооронд зорчуулахгүй бөгөөд КОВИД-19 вирусын сэжигтэй тохиолдол илэрсэн ажилтныг яаралтай орон нутгийн Онцгой комиссын хяналтад авч тусгаарлах байранд байршуулж, дараагийн шатны оношилгоо үйлчилгээнд хамруулна.

3.25. Аж ахуйн нэгж байгууллагууд нь ажилчдын шинжилгээний зардлыг бүрэн хариуцан ажиллана.

3.26. Ээлжээс бууж байгаа болон ээлжид гарч байгаа ажилтнуудыг хооронд нь болон тухайн орон нутгийн иргэдтэй хавьтал үүсгэхгүйгээр ээлж солих ажлыг зохион байгуулна.

3.27. Ээлжид гарч байгаа ажилтнуудын халдваргүйжүүлэлт, хамгааллын дэглэмийг тогтмол баримтлан ажилтнуудынхаа эрүүл мэндийн байдалд тандалт хийж, халууныг нь хэмжин, тэмдэглэл хөтөлсөн байна.

3.28. Ажилтнуудыг ажлын байрнаас өөр газарт зорчуулахгүй байх арга хэмжээг авна. Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад хандаж КОВИД-19 вирусын түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийлгэж, шинжилгээний дүнг харгалзан эрүүл мэндийн байгууллагын зөвлөсний дагуу өөр газарт ажиллуулах асуудлыг шийдвэрлэнэ.

3.29. Коронавируст халдвар /Ковид 19/-ын сэжигтэй тохиолдол илэрсэн үед ашиглах тусгаарлах өрөөг бэлтгэж халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллана.

3.30. Ээлж солих, ээлжээс буулгах ажиллагааг бүрэн хийсний дараа Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албанд мэдээллийг хүргүүлнэ.

Дөрөв. Ажилтны хүлээх үүрэг

4.1. Ээлж солилцох шилжилт хөдөлгөөнд оролцох ажилтан нь энэ түр журмын 3.6, 3.7-д заасан хугацаанд шаардлагатай шинжилгээг өгөх ба асуумжийг үнэн зөв бөглөнө.

4.2. Ажилтнууд нь иргэний болон ажлын үнэмлэхийг өөрийн биед авч явна.

4.3. Тээврийн хэрэгслээр зорчихдоо аж ахуйн нэгж, байгууллагаас тогтоож өгсөн суудалд сууна. Тээврийн хэрэгсэл дотор болон цонхоор ил задгай нус, цэр,

шүлс хаяхгүй, хог хаягдлыг байгууллагаас бэлтгэж өгсөн хогны уутанд битүүмжилж, эцсийн зогсоол дээр ирмэгц жолоочид үлдээнэ.

4.4. Ажилтнууд халдвар хамгааллын дэглэмийг баримталж /хооллохоос бусад нөхцөлд амны хаалтыг авахгүй байх, бээлий өмсөх, нэг удаагийн амны хаалтыг 2 цаг тутам солих, бээлийг тайлсан тохиолдолд гарыг халдваргүйжүүлэх, бусадтай биеэр хүрэлцэхгүй байх, архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, ойролцоох суудлын зорчигч болон олноор нэг дор бөөгнөрч ярилцахгүй байх/ мэргэжлийн байгууллага болон жолоочийн шаардлагыг биелүүлнэ.

4.5. Ажилтан гэртээ амарч байх эхний 14 хоногт аль болохоор гадагш гарахгүй, бусадтай хавьтал үүсгэхгүй байх ба оршин суугаа тухайн бүс нутагт тогтоосон дэглэмийг баримтална.

4.6. Амрах хугацаандаа халуурсан, ханиасан, амьсгал давчдсан зэрэг коронавируст халдварын шинж тэмдэг илэрсэн, өвчтэй хүнтэй хавьтал болсон тохиолдолд оршин суудаг нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж, өгсөн зөвлөмжийг дагаж мөрдөх ба энэ тухай байгууллагын удирдлагадаа нэн даруй мэдэгдэнэ.

4.7. Энэхүү түр журмын 3.6, 3.7-д заасан шинжилгээ өгснөөс хойш ажилладаг газар руугаа, эсхүл гэр рүүгээ явах хүртэлх хугацаанд гадуур гарахгүй, гэртээ, амьдардаг байрандаа өөрийгөө тусгаарлана.

Тав. Ажилтнуудыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл болон жолоочид тавигдах шаардлага, хүлээх үүрэг

5.1. Жолооч нь аж ахуйн нэгж, байгууллагатай хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан ажилтан байх бөгөөд эрүүл мэндийн үзлэгт орж эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамрагдсан байна.

5.2. Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, гарын үсэг зурсан байна.

5.3. Жолооч нь өөрийн болон зорчиж байгаа ажилтнуудын аюулгүй байдлыг хангаж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж, замын туршид агаар сэлгэлтийг анхаарч, агааржуулалтын төхөөрөмжийг тогтмол ажиллуулна.

5.4. Жолооч нь ажил олгогчоос зөвшөөрөөгүй, тухайн чиглэлд зорчих эрхгүй иргэнийг тээвэрлэх, зөвшөөрөгдөөгүй чиглэлд зорчих, зогсохыг зөвшөөрснөөс бусад газарт зогсож, ажилтнуудыг буулгахыг хориглоно.

5.5. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч болон бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтны тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлж, халдваргүйжүүлэлт хийх ажилтны зөвлөмж, зааврыг мөрдөнө.

5.6. Тээвэрлэлтийн явцад сэжигтэй, магадлалтай тохиолдол, шинж тэмдэг илэрсэн ажилтан тогтоогдвол тухайн үед нутаг дэвсгэрт нь зорчиж буй аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабт мэдэгдэж, суурин газарт нэвтрэхгүй, тандалт судалгааны багийг иртэл зорчигчдыг тээврийн хэрэгслээс гаргахгүй байлгах арга хэмжээг авна.

5.7. Ажилтан тээвэрлэх явцад зорчигчийн хэрэглэсэн амны хаалт, бээлий, ахуйн хог хаягдлыг цуглуулж, нийслэл, орон нутаг, уурхайн зөвшөөрөгдсөн хог хаягдлын цэгт битүүмжлэн хаяна. Ил задгай болон бусад зориулалтын бус цэгт хаяхыг хатуу хориглоно.

Зургаа. Ажилтнуудыг тээвэрлэх нисэх компанид тавигдах шаардлага, хүлээх үүрэг

6.1. Ээлж солих ажилтнуудыг нисэх онгоцоор тээвэрлэх аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээд төлбөр хөлсний асуудлаа тухайн ажил олгогчтой тогтсон гэрээ, журмын дагуу биелүүлнэ.

6.2. Авиа компани нь ажил олгогчоос зөвшөөрөөгүй, тухайн чиглэлд зорчих эрхгүй иргэнийг тээвэрлэхийг хориглоно.

6.3. Нисэх багийн бүрэлдэхүүн нь өөрийн болон зорчиж байгаа ажилтнуудын аюулгүй байдлыг хангаж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, агаар сэлгэлтийг анхаарч, агааржуулалтын төхөөрөмжийг тогтмол ажиллуулна.

6.4. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч болон бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтны тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлж, халдваргүйжүүлэлт хийх ажилтны зөвлөмж, зааврыг мөрдөнө.

6.5. Тээвэрлэлтийн явцад сэжигтэй тохиолдол, шинж тэмдэг илэрсэн ажилтан илэрвэл тухайн аймаг, нийслэлийн онцгой комиссын шуурхай штабд мэдэгдэж, суурин газарт нэвтрэхгүй, тандалт судалгааны багийг иртэл зорчигчдыг тээврийн хэрэгсэлээс гаргахгүйгээр байлгана.

6.6. Ажилтан тээвэрлэх явцад зорчигчийн хэрэглэсэн амны хаалт, бээлий, ахуйн хог хаягдлыг цуглуулж, нийслэл, орон нутаг, уурхайн зөвшөөрөгдсөн хог хаягдлыг цэгт битүүмжлэн хаяна. Ил задгай болон бусад цэгт хаяхыг хатуу хориглоно.

6.7. Нисэх онгоцны буудлаас ирж очих хөдөлгөөнийг түр журамд заасан горимын дагуу хэрэгжүүлэх үүргийг ажил олгогч аж ахуйн нэгж хүлээнэ.

Долоо. Бусад

6.1. Энэ түр журмыг зөрчин халдвар, хамгааллын аюулгүй байдлыг алдагдуулсан ажилтан, албан хаагчийн үйлдэл нь Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээргүй бол аж ахуйн нэгж байгууллага нь хөдөлмөрийн гэрээ, болон хөдөлмөрийн дотоод журмын дагуу шаардлагатай хариуцлагын арга хэмжээг авч, хариуцлага тооцон ажиллах.

6.2. Энэ түр журмыг зөрчсөн үйлдэл нь Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр бол зөрчил гаргасан аж ахуйн нэгж байгууллага болон иргэнд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

---oO---